



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/19

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Цамбагарав багийн нутаг дэвсгэр 09 дүгээр гудамжны 02 тоотод байрлах Галсаннамжилын Баянжаргалын /ПЮ92100904/ 817 метр квадрат газар, Цамбагарав багийн нутаг дэвсгэр 09 дүгээр гудамжны 01 тоотод байрлах эмнэлгийн зориулалттай Барагшунфарм ХХК /2808005/-ний 632 метр квадрат газрыг, газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Баттөмөрийн Өсөхбаярт /ПЮ00231311/ 1449 метр квадрат, Ану хатан 2 дугаар гудамжны 201 тоот болгон үйлчилгээний зориулалтаар 10 жилийн хугацаагаар,

2. Жаргалант сумын Баатархайрхан багийн нутаг дэвсгэр Үйлдвэрийн район-1 дүгээр гудамж 28 тоотод байрлах үйлчилгээний зориулалттай Бат-Эрдэнийн Баярмаагийн /ПЗ71111401/ 1581 метр квадрат газрыг, газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу "Тэгш стандарт" ХХК-нд Г.Аюурзана 1 дүгээр гудамжны 100 тоот болгон үйлчилгээний зориулалтаар 10 жилийн хугацаагаар,

3. Жаргалант сумын Буянт багийн нутаг дэвсгэр Эко 1 дүгээр гудамж 14 тоотод байрлах Нэргүйн Баатарнямын /УС71030710/ 400 метр квадрат газрыг, газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Ширнэнгийн Энх-Амгаланд /ПЮ77090217/ мэдээллийн сангийн зургийн дагуу 424 метр квадрат, Жаргалант хайрхан 2 дугаар гудамж 225 тоот болгон гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 3 жилийн хугацаагаар,

4. Жаргалант сумын Цамбагарав багийн нутаг дэвсгэрт байрлах Мэргэжлийн хяналтын газар /9067868/-ын 800 метр квадрат газраас 600 метр

Zax A/19.Ch
02.00035

квадрат газрыг Боловсрол, соёл, урлагийн газарт /9067906/ Лааганы1 дүгээр гудамжны 102 а тоот болгон албан хэрэгцээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар, үлдсэн 200 метр квадрат газрыг мэдээллийн сангийн зургийн дагуу 260 метр квадрат газрыг Мэргэжлийн хяналтын газарт /9067868/ албан хэрэгцээний зориулалтаар 15 жилийн хугацаагаар,

5. Жаргалант сумын Наран багийн нутаг дэвсгэр 26 дугаар гудамжны 32 тоотод байрлах үйлчилгээний зориулалттай Бат-Эрдэнийн Сүхнарангийн /ПЭ87050913/ 65 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Дуламжавын Байгалмаад /ПЮ62051289/ мэдээллийн сангийн зургийн дагуу 396 метр квадрат, болгон үйлчилгээний зориулалтаар 10 жилийн хугацаагаар тус тус эзэмшүүлсүгэй.

6. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлж газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэн, аж ахуй нэгжүүдэд үүрэг болгосугай.

7. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ